



ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ: Монголын Аялал Жуулчлалын Холбоо (МАЖХ) нь 1992 онд Монголын аялал жуулчлалын салбарт ажиллагсад болон анхны аялал жуулчлалын хувийн компаниудын санаачлагаар үүсгэн байгуулагдсан. МАЖХ нь гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, Монгол улсын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх үндсэн зорилго бүхий гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус ТББ бөгөөд БОАЖЯамны зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэдэг, тогтвортой үйл ажиллагаатай, Монголын аялал жуулчлалын салбарын хамгийн том, мэргэжлийн холбоо билээ.

ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТУХАЙ: Тус үзэсгэлэн нь анх 1999 онд МАЖХ-ны гишүүн байгууллагуудын санаачлагаар зохиогдож эхэлсэн түүхтэй ба энэ жил 21 дахь жилдээ 2020 оны 03 дугаар сарын 27, 27, 29-ний өдрүүдэд зохиогдоно. Үзэсгэлэн нь цар хүрээ, оролцогчдын тоогоор Монголд зохиогддог хамгийн том үзэсгэлэн төдийгүй аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийг хооронд нь холбож, шинэ бизнесийн түнш олох, гэрээ хэлэлцээр хийх, бараа бүтээгдэхүүнээ сурталчлах, борлуулах зэрэг бизнесийн төрөл бүрийн боломжийг бүрдүүлж өгдөг давуу талтай. Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутгийн аялал жуулчлалын компани, жуулчны баазууд өөрийн аймгийн аялал жуулчлалын газраар дамжуулан нэгдсэн зохион байгуулалттай оролцдог уламжлалтай болоод байна. 2019 онд 21 аймаг нэгдсэн зохион байгуулалттайгаар, тур оператор, жуулчны бааз, ресторан зоогийн газар, их дээд сургууль, сургалтын төв, аяллын хэрэгсэл ханган нийлүүлэгч, гар урлалын компани, дуу бүжгийн чуулга, музей зэрэг дотоодын 300 гаруй аж ахуйн нэгж байгууллага, Түрк, ОХУ, Япон, Сологос, БНХАУ-ын аялал жуулчлалын байгууллагын төлөөлөл оролцож, үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж байгаа билээ.


Зохион байгуулагчид 2013 оноос үзэсгэлэнгийн түнш аймгийг шалгаруулж, хамтран зохион байгуулж ирсэн уламжлалтай бөгөөд өмнөх жилүүдэд Өвөрхангай, Өмнөговь, Архангай, Дорноговь, Ховд, Завхан, Увс аймгууд түншээр оролцож, аймаг орон нутгаа сурталчлан оролцсон бол 2020 онд Хэнтий аймаг үзэсгэлэнгийн түнш аймгаар оролцохоор шалгарч, шилжин явах тугаа хүлээн авсан билээ.

БОЛОМЖ: Гадаадын бизнес эрхлэгчид хүрэлцэн ирэх учир туршлага солилцох, бизнесийн шинэ түнштэй болох, жуулчны байр сууцны үйлчилгээ эрхлэгчдийн энэ зуны үнийг хөнгөлттэй үнээр авах, баталгаажуулах, аялал жуулчлалын бизнесийн эрх зүй, олон улсын стандарт, шинэ чиг хандлагын талаар гадаад дотоодын судлаачдын лекцэнд хамрагдах зэрэг боломжоор хангагдана.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

- | | |
|--|---|
| <input type="checkbox"/> Холбоо/Төрийн бус байгууллага | <input type="checkbox"/> Музей/Сүм хийд/Үзвэрийн газар |
| <input type="checkbox"/> Тур агент | <input type="checkbox"/> Агаарын тээвэр/Төмөр зам/Авто тээвэр |
| <input type="checkbox"/> Тур оператор | <input type="checkbox"/> Ресторан/Зоогийн газар |
| <input type="checkbox"/> Зочид буудал | <input type="checkbox"/> Худалдаа үйлчилгээ |
| <input type="checkbox"/> Резорт, Жуулчны бааз | <input type="checkbox"/> Гар урлал/Бэлэг дурсгал |
| <input type="checkbox"/> Авто буудал/Буурчийн газар/Дэн буудал | <input type="checkbox"/> Аяллын дагалдах хэрэгсэл үйлдвэрлэгч, борлуулагчид |
| <input type="checkbox"/> Амралт/Рашаан сувиллын газар | <input type="checkbox"/> Спорт клуб/Цогцолбор төвүүд |
| <input type="checkbox"/> Их дээд сургууль, сургалтын төв | <input type="checkbox"/> Бусад, _____ |
| <input type="checkbox"/> Дурсгалт/Тусгай хамгаалалттай газар | |

Бизнес уулзалт: Монголын аялал жуулчлалын салбарын тур компани, жуулчны бааз, зочид буудал, тээврийн үйлчилгээний компани зэрэг томоохон аж ахуйн нэгжүүдтэй гэрээ хэлэлцээр байгуулах, шинээр түншлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, туршлага солилцох боломжоор хангагдана.



Семинар хурал хэлэлцүүлэг: Хурлын танхимд өдөр бүр тодорхой цагт сонирхолтой уулзалт семинар хэлэлцүүлэг зохион байгуулах ба дээрх хурал хэлэлцүүлэгт аялал жуулчлалын маркетинг, шинэ дэвшилтэд технологи, хүний нөөц болон ивэнт арга хэмжээтэй холбоотой сургалтуудыг явуулахаас гадна, үзэсгэлэнд оролцогч байгууллагууд шинэ бүтээгдэхүүний сурталчилгааг хийх, жуулчдын зорин очих газрууд шинэ маршрут, аяллын хөтөлбөрийн танилцуулгаа хийх боломжтой юм. Дээрх чиглэлээр илтгэл тавих сонирхолтой байгууллагууд МАЖХ-нд саналаа ирүүлнэ. Илтгэл семинар бүр 20 минутанд багтаж дуусна. Оролцох байгууллага илтгэлийг дээр Microsoft Office PowerPoint, Prezi файл дээр бэлтгэж оролцоно.

БАЙРШИЛ: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, "Мишээл ЭкспоТөв"

